

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Малын генетик нөөцийн тухай хууль тогтоомж

2.1.Монгол Улсын малын генетик нөөцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль², энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн хамрах хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсад үржүүлж байгаа мал, түүний үржүүлгийн бүтээгдэхүүн болон тэдгээртэй холбогдсон уламжлалт мэдлэгт хамааралтай харилцаанд үйлчилнэ.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“мал” гэж таван хошуу мал болон гэршүүлэн үржүүлж байгаа бусад тэжээвэр амьтныг;

4.1.2.“малын генетик нөөц” гэж мал, түүний үржүүлгийн бүтээгдэхүүн болон уламжлалт мэдлэгийг;

4.1.3.“малын үржүүлгийн бүтээгдэхүүн” гэж малын удамшлын мэдээлэл агуулсан ДНХ, РНХ, биеийн эс, өндгөн эс, үр, хөврөл, сорьц болон бусад бүрэлдэхүүнийг;

1 Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

2 Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

4.1.4. “уламжлалт мэдлэг” гэж малын генетик нөөцийг ашиглах явцад өвлөгдөн уламжлагдаж ирсэн арга, аман болон бичгэн хэлбэрийн мэдээлэл, дадал заншлыг;

4.1.5. “малын генетик нөөцийн төлөв байдал” гэж үнэлгээний үндсэн дээр тогтоосон малын генетик нөөцийн төрөл, зүйл, үүлдэр, омог, тоо хэмжээ, чанар, хүрэлцээ, хангамж, тэдгээрийн хувьсал, өөрчлөлтийг;

4.1.6. “цөм сүрэг” гэж тухайн үүлдэр, омгоос ашиг шимийн хэмжээ, чанараар шилэн сонгон үржүүлж байгаа бүлэг малыг;

4.1.7. “уугуул орчин” гэж малын өвөрмөц шинж байдлаа олж авсан, хадгалж ирсэн орчин зүйн бүрдлийг;

4.1.8. “нутагшуулсан орчин” гэж малыг уугуул орчноос нь шилжүүлж дасгасан орчин зүйн бүрдлийг;

4.1.9. “малын генийн сан” гэж тусгай орчинд хадгалагдаж байгаа малын үржүүлгийн бүтээгдэхүүний сорьц, дээж бүхий цуглуулгыг;

4.1.10. “гойд ашиг шимт мал” гэж үүлдэр, омгийн мал сүргээс үржил, ашиг шимийн нэг буюу хэд хэдэн чанараар онцлог давуу болох нь баталгаажсан малыг;

4.1.11. “гарваль улс” гэж уугуул орчиндоо байгаа малын генетик нөөцийг эзэмшигч улс орныг;

4.1.12. “малын генетик нөөцийг ашиглах” гэж малын генетик нөөцийн ашигт шинж чанарыг хөгжүүлж үр шим, ашгийг нь хүртэх үйл ажиллагааг;

4.1.13. “малчин” гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” тухай хуулийн 3.1.9-д заасныг;

4.1.14. “мал бүхий этгээд” гэж Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4.1.3-д заасныг;

4.1.15. “хуулийн этгээд” гэж Иргэний хуулийн 25.1-д заасныг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙГ БҮРТГЭХ, ТӨЛӨВ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ

5 дугаар зүйл. Малын генетик нөөцийн бүртгэл

5.1. Малын генетик нөөцийн бүртгэл дараах хэлбэртэй байна:

5.1.1. малын бүртгэл;

5.1.2. үржүүлгийн бүтээгдэхүүний бүртгэл;

5.1.3. малын удам зүйн үнэлгээний бүртгэл;

5.1.4. малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийн бүртгэл.

5.2. Энэ хуулийн 5.1.1-д заасан бүртгэлд малын төрөл, үүлдэрлэг байдал, удам гарваль, нас, хүйс, өсөлт хөгжилтийн болон ашиг шимийн үзүүлэлт, малын байршил, үржүүлэгч этгээдийн нэр, улсын бүртгэлийн дугаар, хаяг, малын шилжилт, хөдөлгөөнийг бүртгэлийг хамааруулна.

5.3.Энэ хуулийн 5.1.1, 5.1.4-д заасан бүртгэлийг сум, дүүргийн тасаг хариуцаж, энэ хуулийн 11.3-д заасан үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээдтэй хамтран хийж, мэдээллийг аймаг, нийслэлийн байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

5.4.Энэ хуулийн 5.1.2-д заасан бүртгэлд үржүүлгийн бүтээгдхүүний төрөл зүйл, хэлбэр, тоо хэмжээ, чанарын үзүүлэлт, үйлдвэрлэгдсэн огноо, үйлдвэрлэгчийн байршил, улсын бүртгэлийн дугаар, ашиглалтын төлөв байдлын бүртгэлийг хамааруулах ба энэ хуулийн 15.1-д заасан байгууллага бүртгэлийг хариуцан гүйцэтгэнэ.

5.5.Малын генетик нөөцийн мэдээллийг нэгтгэх, ашиглах, хянах, олон улсын болон бүс нутгийн мэдээллийн сүлжээтэй мэдээлэл солилцох, хэрэглэгчдийг мэдээллээр хангах үндэсний мэдээллийн нэгдсэн сан (цаашид “нэгдсэн сан” гэх)-ийн үйл ажиллагааг малын генетик нөөцийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

5.6. Малын генетик нөөцийг бүртгэх, үүлдэр, омгийн малыг кодлох, энэ хуулийн 5.5-д заасан нэгдсэн санг бүрдүүлэх, тайлагнахтай холбогдсон журмыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын бүртгэл статистикийн асуудал хариуцсан төрийн байгууллага хамтран батална.

5.7.Малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгэх үйл ажиллагааны аргачлалыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6 дугаар зүйл. Малын удам зүйн үнэлгээ

6.1.Малын удам зүйн үнэлгээнд үржлийн малын удам гарваль, ашиг шим, зүс, галбир, бие цогцос, үр төлийн чанар, геномын өвөрмөц тогтоцын үзүүлэлт хамаарна.

6.2.Удам зүйн үнэлгээг энэ хуулийн 15.1-д заасан төрийн үйлчилгээний байгууллага, салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, энэ хуулийн энэ хуулийн 11.3-д заасан үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж холбогдох арга зүй, аргачлал, зааврын дагуу хийнэ.

6.3.Энэ хуулийн 6.1-д заасан үнэлгээнд хамрагдсан малыг хувийн дугаараар ялган тэмдэглэнэ.

6.4.Үржлийн малын удам гарваль, ашиг шим, зүс, галбир, бие цогцос, үр төлийн чанарын үнэлгээг энэ хуулийн 11.3-т заасан үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж малчин, малын өмчлөгч, эзэмшигчтэй хамтран гүйцэтгэж, бүртгэл хөтөлнө.

6.5.Малын геномын өвөрмөц шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлох молекул генетикийн шинжилгээг энэ хуулийн 15.1-д заасан төрийн байгууллага, салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, лавлагаа лаборатори тус тус хийж болох ба энэ тухай бүртгэл хөтөлнө.

6.6.Энэ хуулийн 6.3, 6.4-д заасан бүртгэлийн мэдээллээ хариуцагч нь тухай бүр мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.

6.7.Удам зүйн үнэлгээ болон үржлийн ажлын хүрсэн түвшингийн хянан

магадлагааг үндэслэн үржлийн малыг үүлдэр, үүлдрийн хэсэг, үржлийн хэсэг, омгоор(цаашид “үүлдэр, омог” гэх) баталгаажуулна.

6.8.Монгол улсад оруулснаас хойш тав ба түүнээс дээш жил болсон үүлдрийн малыг нутагшсан үүлдрээр хянан баталгаажуулж болно.

6.9.Үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журмыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.10.Энэ хуулийн 6.7-д заасан малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах зардлыг захиалагч тал хариуцна.

6.10.Энэ хуулийн 6.3-т заасан арга хэмжээний зардлыг малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд хариуцна.

6.11. Малд удам зүйн үнэлгээ хийх, мэдээллийг нэгтгэн баталгаажуулах үйл ажиллагааг малын генетик нөөцийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага удирдлага зохион байгуулалтаар хангах ба малын үүлдэр, ашиг шимийн стандартыг шинээр, шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.

7 дугаар зүйл. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох

7.1.Малын генетик нөөцийн төлөв байдлыг олон улсын мэргэжлийн байгууллагын зөвлөлмж, зааврын дагуу гурван жил тутам малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон мэргэшсэн шинжээчийн баг тодорхойлно.

7.2.Шинжээчийн баг малын генетик нөөцийн төлөв байдлын тайланг Үндэсний зөвлөлдөх хороогоор хэлэлцүүлж гарсан дүгнэлтийг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн гуравдугаар улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

7.3.Засгийн газар малын генетик нөөцийн төлөв байдлын тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлнэ.

7.4.Малын генетик нөөцийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд бүс нутгийн болон олон улсын түвшинд Монгол Улсын малын генетик нөөцийн асуудлыг хариуцах орон тооны Үндэсний зохицуулагчтай байна. байх бөгөөд энэ нь Ерөнхий мал зүйч байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙГ АШИГЛАХ, СУДЛАН ХӨГЖҮҮЛЭХ

8 дугаар зүйл. Малын генетик нөөцийг ашиглах

8.1.Малын генетик нөөцийг дараахь зориулалтаар ашиглаж, судлан хөгжүүлнэ:

8.1.1.бүс нутгийн онцлогт тохирсон малын үүлдэр, омог шинээр бий болгох;

8.1.2.малын үүлдэрлэг байдлыг батжуулан сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх;

8.1.3. малын эрсдэл даах чадавхийг бататган бэхжүүлэх;

8.1.4. мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх;

8.1.5. мал аж ахуйн салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

8.1.6. тэжээллэг, аюулгүй хүнс үйлдвэрлэж, нийлүүлэх;

8.1.7. үндэсний үйлдвэрт чанартай түүхий эд нийлүүлэх;

8.1.8. үнэ цэнийн сүлжээ хөгжүүлэх;

8.1.9. генетик нөөцийг ашигласнаас үр ашиг хүртэх;

8.1.10. бусад.

8.2. Малын ашиг шимийн чиглэл, үүлдэр, омгийн онцлогийг харгалзан сүргийн зохистой бүтэц, харьцааг энэ хуулийн 16.1-д заасан үндэсний хөтөлбөрт тусгаж зохицуулна.

8.3. Малын генетик нөөцийг ашиглахад малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд дараахь эрх эдэлнэ:

8.3.1. генетик нөөц ашигласны үр шимийг хүртэх;

8.3.2. мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ авах;

8.3.3. энэ хуулийн 13.5-д заасан урамшуулал авах;

8.3.4. үржлийн мал бойжуулах, борлуулах.

8.4. Малын генетик нөөцийг ашиглахад малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд дараахь үүрэг хүлээнэ:

8.4.1. тухайн бүс нутагт үржүүлэхээр зөвшөөрөгдсөн үүлдэр, омгийн хээлтүүлэгч ашиглах;

8.4.2. үр, хөврөлийг энэ хуулийн 11.3-д заасан мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж, мэргэжилтний хяналтын дор ашиглах;

8.4.3. бог малын хээлтүүлэгчийг нийлүүлгийн бус улиралд эх сүргээс тусгаарлах, зөвхөн үржлийн насны малыг нийлүүлэгт оруулах;

8.4.4. мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний жишиг үнээр тогтоосон зардлыг хариуцах;

8.4.5. малын ашиг шимт чанарыг үнэлүүлэх, баталгаажуулах, үржлийн малын удам гарваль, ашиг шимийн бүртгэл хөтлөх;

8.4.6. малын генетик нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах талаар

хууль тогтоомжийг биелүүлэх;

8.4.7.үржлийн малын гэрчилгээ болон шилжилт хөдөлгөөний тодорхойлолтыг сум, дүүргийн тасгаас авах;

8.4.8.малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгүүлэх, түгээн дэлгэрүүлэх.

8.4.9.малыг ялган тэмдэгжүүлж, улсын нэгдсэн бүртгэлд хамруулах.

8.5.Үүлдэр, омог бүрт цөм сүрэг бүрдүүлнэ. Цөм сүргийг бүрдүүлэхэд өмчийн хэлбэр харгалзахгүй.

8.6.Малын генетик нөөцийн асуудал хариуцсан төрийн байгууллагын дэргэд бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зөвлөх чиг үүрэг бүхий малын үүлдэр, ашиг шимийн орон тооны бус зөвлөлийг байгуулж болно.

9 дүгээр зүйл. Малын генетик нөөцийг ашиглах тусгай зөвшөөрөл

9.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан ажил, үйлчилгээг эрхлэх иргэн, хуулийн этгээд нь доор дурдсан агуулга бүхий хүсэлтээ малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана:

9.1.1.үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх үр, үр хөврөлийн тоо, сорьцын хэмжээ, импортлох сайжруулагч мал болон экспортлох малын төрөл, зүйлийн нэр;

9.1.2.ашиглах зорилго, зориулалт, үйл ажиллагааны чиглэл;

9.1.3.экспортлох, импортлох улс, хуулийн этгээдийн нэр;

9.1.4.гарваль болон нийлүүлэгч улсын нэр;

9.1.5.хүлээн авах, хүргэх хэлбэр, ажил гүйцэтгэх байгууллагын нэр.

9.2.Тусгай зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 9.1-д заасан хүсэлтэд дараахь бичиг баримтыг хавсаргана:

9.2.1.хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар;

9.2.2.малын удам гарвацийн тодорхойлолт;

10.2.3.энэ хуулийн 12.2-т заасан гэрээний хувь.

9.3.Малын генетик нөөцийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 9.1-д заасан хүсэлтийг малын генетик нөөцийн Үндэсний зөвлөлдөх хорооны дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл олгох, эсэхийг шийдвэрлэнэ.

9.4.Малын генетик нөөцийн Үндэсний зөвлөлдөх хороо хүсэлтийг ажлын таван өдөрт багтаан мэргэжлийн түвшинд хянан үзэж, дүгнэлт гаргана.

9.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч малын генетик нөөцийг ашигласан үйл ажиллагааны тайланг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны

төв байгууллагад жилд 1 удаа ирүүлнэ.

9.6.Импортоор сайжруулагч мал авах бол тухайн малын удам гарваль, шинж тэмдгийн гадаад илрэл, генийн хувьслын үзүүлэлтийг үнэлэх, шилэн сонгох үйлчилгээг энэ хуулийн 11.3-д заасан итгэмжлэл бүхий мэргэжилтнээр хийлгэж албан ёсны тодорхойлолт гаргуулна.

9.7.Монгол Улсаас мал экспортлох бол малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага иргэн, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл, энэ хуулийн 10.2-т заасан гэрээг үндэслэн зүйл тус бүрт нэг лиценз олгоно.

9.8.Судалгаа шинжилгээний зорилгоор малын үржүүлгийн бүтээгдэхүүнийг экспортлох бол ижил зүйлийн 5 хүртэл сорьцод нэг лиценз олгож болно.

9.9.Мал экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч нь лицензи авахдаа экспортлох малын төрөл, үүлдэр, хувийн дугаар, тоо хэмжээг хүсэлтэнд хавсаргаж ирүүлнэ.

9.10.Малын үржүүлгийн бүтээгдэхүүнийг экспортлох бол тухайн төрөл, зүйл, цуврал тус бүрийн сорьцын ижил хувийг малын үндэсний генийн санд заавал байршуулна.

9.11.Тусгай зөвшөөрлөөр ашиглагдаж байгаа малын генетик нөөцийн бүртгэл, технологийн хяналтыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

10 дугаар зүйл. Малын генетик нөөцийг судлан хөгжүүлэх

10.1.Малын генетик нөөцийг судлан хөгжүүлэх үйл ажиллагааг Шинжлэх ухаан, технологийн тухай² хуулийн 11.2.1-11.2.3, Инновацийн тухай хуулийн³ 27.2-д заасан байгууллага, энэ хуулийн 11.3-т заасан үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж гүйцэтгэнэ.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан байгууллага хоорондоо болон гадаадын иргэн, хуулийн этгээдтэй малын генетик нөөцийг судлан хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах бол гэрээ байгуулна.

10.3.Энэ хуулийн 10.2-д заасан гэрээнд дараахь нөхцөлийг тусгана:

10.3.1.судалгаа туршилт явуулах үндэслэл, зорилго;

10.3.2.төрөл, зүйлийн нэр, тоо хэмжээ;

10.3.3.гарваль улс;

10.3.4.судалгаа явуулах хугацаа;

10.3.5.биоаюулгүй байдлыг хангах зохицуулалт;

10.3.6.оюуны өмчийн эрхийн зохицуулалт, технологи дамжуулах нөхцөл;

10.3.7.судалснаас хүлээж буй үр дүн, ашиг хүртэх хэлбэр, түүний тоогоор илэрхийлсэн үзүүлэлт;

10.3.8.маргаан шийдвэрлэх зохицуулалт;

10.3.9.бусад.

10.4.Судалгаа хөгжлийн чиглэлээр үүлдэр, омгийн малд туршилт, судалгаа, шинжилгээ явуулах бол зохион бүтээгч, хамтран бүтээгч, өв залгамжлагч, эсхүл түүний эрх олгосон этгээдээс зөвшөөрөл авна.

10.5.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн бодит өсөлт бий болгох биотехнологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

10.6.Малын генетик нөөцийн судалгаа, туршилтын үр дүн, мэдээлэл нь нэгдсэн сангийн бүрэлдэхүүн хэсэг байна.

11 дүгээр зүйл.Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ

11.1.Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, үзлэг, ангилалт хийх, малын удам гарваль, ашиг шимийн гарц, чанарыг тодорхойлох, үр төлийн шинж чанарыг үнэлэх, удам зүйн үнэлгээ хийх, хянан баталгаажуулах, үржил селекцийн төлөвлөлтийг боловсруулах, сайжруулагч малыг үржилд тохируулан сонгох, цөм сүрэг бүрдүүлэх, малд зохиомол хээлтүүлэг хийх, гойд ашиг шимт мал шалгаруулах үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, үржлийн мал, малын гаралтай үржүүлгийн бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, малын тэжээллэг, арчилгаа, маллагаа, үржил селекцийн ажлын технологийн чиглэлээр малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн зааварчилгаа, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа (цаашид “малын үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ” гэх)-г хамааруулна.

11.3.Мэргэжлийн итгэмжлэл, зэрэг, дэв бүхий мэргэжилтэн, эсхүл тэдгээртэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан, үржил-селекцийн тухайлсан хөтөлбөрөө эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан хуулийн этгээд үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний хувийн хэвшлийн нэгж /цаашид “үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж” гэх/ байгуулахдаа харьяалах аймаг, нийслэлийн малын генетик нөөцийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлснээр мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг эрхлэх эрхтэй болно.

11.4.Мал сүрэгт явуулах үржүүлгийн хөтөлбөрийн чиглэлээс хамаарч үржүүлгийн ажилд олгох итгэмжлэл шаталсан хэлбэртэй байх ба Мэргэжлийн итгэмжлэл, зэрэг дэв олгох, хүчингүй болгох, сунгах, бүртгэх журмыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.5.Энэ хуулийн 16.3-д аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллага мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх мэргэжилтэнд мэргэжлийн итгэмжлэл олгоно.

11.6.Малын генетик нөөцийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг, дэв олгоно.

11.7.Энэ хуулийн 11.3-т заасан үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж нь малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд болон тухайн сум, дүүргийн Засаг

даргатай гурвалсан гэрээ байгуулсны үндсэн дээр холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн холбогдох ажил, үйлчилгээг эрхэлнэ.

11.8.Үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

11.8.1.энэ хуулийн 11.2-т заасан стратегид нийцүүлэн мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний стандарт, технологийг мөрдөж ажиллах;

11.8.2.үүлдэр, омгоос цөм сүрэг бүрдүүлэх, өсвөр малыг үржилд шилэн сонгох, ялган суурилах, үржлийн нас хүртэл бойжуулах, борлуулах;

11.8.3.тогтоосон хугацаанд үржлийн малд үзлэг, ангилалт, тохируулан сонголт хийх, бүртгэх;

11.8.4.бог малын хээлтүүлэгчийг сүргээс тусгаарлан, хяналтад авч бүртгэх, түрээсийн гэрээгээр ашиглуулах;

11.8.5.малын нөхөн үйлдвэрлэлийг зохицуулах, биотехнологийн ололт, биотехникийн арга нэвтрүүлэх;

11.8.6.энэ хуулийн 11.5-д заасан гэрээний дагуу зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ эрхлэх, малын тэжээллэг маллагааны технологийг мөрдүүлэх малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх;

11.8.7.малын генетик нөөцийн ашиглалтын асуудлаар санал боловсруулах, эрх бүхий байгууллага, этгээдээр шийдвэр гаргуулах, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

11.8.8.гойд ашиг шимт мал сонгон шалгаруулах, үржлийн малын үзэсгэлэн, худалдааг сум, дүүргийн төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;

11.8.9.мал эрлийзжүүлгийг хяналтгүй явуулж, малын үүлдэрлэг байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагааг таслан зогсоох;

11.8.10.үржүүлгийн бүтээгдэхүүн болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын үзлэг, шинжилгээ хийж бүртгэх, малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээдэд тодорхойлолт олгох;

11.8.11.энэ хуулийн 11.6.3, 11.6.4, 11.6.10-д заасан бүртгэлийн мэдээллийг сум, дүүргийн тасагт хүргүүлэх.

11.9.Малын генетик нөөцийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь малын генетик нөөцийн асуудал хариуцсан орон нутгийн төрийн байгууллагын бүтцийн алба, тасаг, үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж, итгэмжлэлтэй мэргэжилтнийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

11.10.Үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж өөрийн байршиж байгаагаас өөр нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд тухайн сум, дүүргийн тасагт хүсэлтээ илэрхийлж бүртгүүлэн гэрээний дагуу ажиллана.

11.11.Малын үржлийн ажлын стратеги болон үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний төрөл, жишиг үнийг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙГ ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ

12 дугаар зүйл. Малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах хэлбэр

12.1.Малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах үйл ажиллагаа дараахь хэлбэртэй байна:

12.1.1.уугуул орчинд;

12.1.2.нутагшуулан;

12.1.3. тусгай орчинд.

12.2.Монгол мал, түүнээс гаралтай үүлдэр, омгийг тухайн бүс нутагт цэврээр үржүүлж уугуул орчинд хамгаална.

12.3.Тодорхой зорилгоор гадаад улсаас оруулж ирсэн болон үржлийн зориулалтаар нутаг шилжүүлсэн үүлдэр, омог, тэдгээрийг ашиглан бий болсон үржлийн малыг хязгаарлагдмал хүрээнд нутагшуулан үржүүлж хамгаална.

12.4.Үржүүлгийн бүтээгдэхүүнийг зөвхөн тусгай орчинд хадгалж малын үндэсний генийн санг бүрдүүлж хамгаална.

12.5.Үржүүлгийн бүтээгдэхүүнийг хадгалах нөхцөл, аргыг стандартаар тогтооно.

13 дугаар зүйл. Мал хамгаалах

13.1.Энэ хуулийн 16.1-д заасан үндэсний хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг улсын хэмжээнд генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

13.2.Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох журмыг Засгийн газар батална.

13.3.Импортлох мал, үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг жил бүр Засгийн газар тогтооно.

13.4.Тоо толгой, тархалтын хувьд доройтолд орсон болон мөхөж болзошгүй байдалд хүрч буй зүйл, үүлдрийг тусгайлан хамгаалж, үржүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн малчин, мал бүхий этгээдэд Засгийн газраас дэмжлэг, урамшуулал үзүүлж болно.

13.5.Мэргэжлийн холбоод нь мал хамгаалах үйл ажиллагааны талаар санал, дүгнэлтийг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

13.6.Биологийн олон янз байдал, удам зүйн үнэт чанарын хувьд өвөрмөц, хязгаарлагдмал нөөц, тархалт, ашиглалт бүхий мал, зүйлийг хамгаалах арга хэмжээг Засгийн газраас олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу тусгай хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл. Мал хамгаалах талаар малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээдийн үүрэг

14.1.Мал хамгаалах талаар малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд дараахь үүрэг хүлээнэ:

14.1.1.малыг байгалийн эрсдлээс хамгаалах нөхцлийг бүрдүүлэх, тэжээл, ус, хашаа байраар хангах;

14.1.2.малын ашиг шимийн чиглэл, биологийн онцлогт тохирсон тэжээллэг, арчилгаа маллагааны ая тухтай, аюулгүй нөхцөлөөр хангах;

14.1.3.баталгаажсан үүлдэр, омгийн малыг нутагшсан болон уугуул орчинд нь үржүүлж хамгаалах;

14.1.4.малыг сургах, эдлэх, харьцахдаа айлгаж зовоохгүй байх, зориулалтын уламжлалт тоног, хэрэгсэл ашиглах;

14.1.5.малын үүлдэрлэг байдал алдагдуулахыг хориглох.

14.1.6.мал хариулах, тууварлахад уламжлалт арга, хэрэгсэл ашиглах;

14.1.7.мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг энэ хуулийн 11.3-д заасан үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжээр гүйцэтгүүлэх;

14.1.8.жил бүр малаа үзлэг, ангилалтад бүрэн хамруулж стандартын шаардлагад тэнцэхгүй малыг заазлах, хээлтүүлэгчийг үржлээс хасах.

15 дугаар зүйл. Малын үндэсний генийн санг хамгаалах

15.1.Энэ хуулийн 12.4-д заасан малын үндэсний генийн санг малын генетик нөөцийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харъяа төрийн үйлчилгээний байгууллага хариуцна.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан төрийн байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.2.1.малын генетик нөөцийг доройтох, мөхөх, устахаас сэргийлж хамгаалах, хадгалах, баяжуулах болон үйлдвэрлэл явуулах зорилгоор малын генийн санг бүрдүүлэх;

15.2.2.дотоодод ашиглах болон экспортлох үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах, тодорхойлолт олгох;

15.2.3.импортын үржүүлгийн бүтээгдэхүүнийг бүртгэх, гарал үүсэлд хяналт тавих, генийн санд тусгайлан хадгалах, тэдгээрийг батлагдсан үржлийн хөтөлбөрийн дагуу ашиглахаар хуваарилах, ашиглалтын үр дүнг тооцох;

15.2.4.үржүүлгийн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, шаардлагыг ханган, ашиглалтыг энэ хуулийн 13.2-т заасан стратегийн дагуу явуулах, холбогдох бүртгэл, мэдээллийг нэгдсэн санд оруулж байх;

15.2.5.малын чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах үржүүлэг, технологийн ажил үйлчилгээнд биотехнологийн ололт нэвтрүүлэх, нутагшуулах, дэлгэрүүлэх;

15.2.6.мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг арга зүйн удирдлагаар хангах;

15.2.7.мал үржүүлгийн технологчийг бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;

15.2.8.зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний хүрээг тогтоох, өргөтгөх, шаардлагат багаж, тоног төхөөрөмж, урвалжаар хангах;

15.2.9.үүлдэр, омгийн мал, түүний үржүүлгийн бүтээгдэхүүнд молекул генетикийн шинжилгээ хийх.

15.3.Малын генийн үндэсний санд үржүүлгийн бүтээгдэхүүн байршуулах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих болон гойд ашиг шимт мал шалгаруулах журам, энэ хуулийн 15.1-д заасан байгууллагын үйл ажиллагааны бүтэц, орон тоог малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.4.Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага нь донор болон тээгч малтай байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

16 дугаар зүйл. Малын генетик нөөцийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх

16.1.Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, энэ хуулийн 7.3-т заасан тайланг үндэслэн малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, ашиглах үндэсний хөтөлбөрийг Засгийн газар батална.

16.2.Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд малын генетик нөөцийн асуудал хариуцсан байгууллага, сум, дүүрэгт тасаг, энэ хуулийн 11.3-д заасан үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж тус тус хариуцан гүйцэтгэнэ.

16.3.Малын генетик нөөцийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.3.1.малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, сурталчлах, тайлагнах;

16.3.2.орон нутгийн удирдлага, сум дүүргийн тасаг, үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийг удирдлагаар хангах, зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх;

16.3.3.үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг бүртгэх;

16.3.4.мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд технологийн хяналт тавих;

16.3.5.мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ, энэ хуулийн 5.1-т заасан бүртгэл, малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээдэд төрөөс олгох урамшуулалтай холбоотой мэдээллийг энэ хуулийн 5.5-д заасан нэгдсэн санд оруулах;

16.3.6.үржлийн малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, гойд ашиг шимт мал сонгон шалгаруулах, борлуулах, солилцох ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;

16.3.7.үүлдэр, омгийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;

16.4.Малын генетик нөөцийн асуудал хариуцсан сум, дүүргийн тасаг дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.4.1.малын генетик нөөцийг ашиглах, хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, сурталчлах, тайлагнах;

16.4.2.үржүүлэг, технологийн ажил үйлчилгээнд малыг тогтоосон хугацаанд бүрэн хамруулах, энэ хуулийн 11.5-д заасан гэрээний биелэлтэд хяналт тавих;

16.4.3.мал сүргийн оновчтой бүтэц, зохистой харьцаа, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироонд хяналт тавих;

16.4.4.малын генетик нөөцийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, бүртгэлийн мэдээллийг аймаг, нийслэлийн байгууллагад хүргүүлэх;

16.4.5.генетик нөөцийг хамгаалах, түүнтэй холбоотой судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

16.4.6.сургах, дадлагажуулах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, мэдээллээр хангах, уламжлалт мэдлэгийг баримтжуулан бүртгэх, түгээн дэлгэрүүлнэ.

16.5.Аймаг, нийслэлд малын генетик нөөцийн асуудал хариуцсан байгууллага нь шинээр байгуулагдах болон шинэчлэн зохион байгуулагдаж байгаа үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг бүртгэхдээ дараахь шаардлага хангасан эсэхийг магадлаж ажлын таван өдөрт багтаан бүртгэх, эс зөвшөөрвөл албан бичгээр хариу мэдэгдэнэ.

16.5.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

16.5.2.итгэмжлэлийн хуулбар;

16.5.3.үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ үзүүлэх хүрээ, нэр төрөл, зорилго чиглэлээ тодорхойлсон бизнес төлөвлөгөө;

16.5.4.харьяа сум, дүүргийн тасаг энэ хуулийн 16.5.1, 16.5.2, 16.5.3-д

заасан шаардлагыг хангасан тухай дүгнэлт.

16.6.Аймаг, нийслэлд малын генетик нөөцийн асуудал хариуцсан байгууллага нь энэ хуулийн 16.5.1, 16.5.2, 16.5.3-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтыг үнэн зөв, бүрэн ирүүлсэн бол бүртгэхээс татгалзах эрхгүй.

17 дугаар зүйл. Малын генетик нөөцийн Үндэсний зөвлөлдөх хороо

17.1.Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд орон тооны бус Үндэсний зөвлөлдөх хороо /цаашид “хороо” гэх/ ажиллана.

17.2.Энэ хуулийн 7.4-д заасан Үндэсний зохицуулагч нь хорооны дарга байх ба Хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын төрийн болон төрийн бус байгууллага, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, үүлдрийн зөвлөл, үйлдвэрлэгч, боловсруулах салбарын болон мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулна.

17.3.Хорооны гишүүнд улс төрийн болон төрийн тусгай албаны төлөөллийг оролцуулахгүй.

17.4.Хорооны нарийн бичгийн дарга нь малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажилтан байна.

17.5.Хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.6.Хороо дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.6.1.уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйг бүсчилэн хөгжүүлэх талаар санал боловсруулах;

17.6.2.салбар болон салбар дундын түвшинд малын генетик нөөцийн үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах талаар чиглэл гаргах;

17.6.3.тухайн жилд импортлох, экспортлох генетик нөөц, нутагшуулах малын ашиг шимийн чиглэл, тоо хэмжээний талаар зөвлөмж гаргах;

17.6.4.малын генетик нөөцийг хамгаалах, ашиглах, судлан хөгжүүлэх болон энэ хуулийн 7.2-т заасан тайланг хэлэлцэн дүгнэлт гаргах;

17.6.5.энэ хуулийн 8.6-д заасан үүлдэр ашиг шимийн зөвлөлийн үйл ажиллагаанд чиглэл өгөх;

17.6.6.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл. Малын генетик нөөцийн үйл ажиллагааны санхүүжилт

18.1.Малын генетик нөөцийн үйл ажиллагааны санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

18.1.1.улсын болон орон нутгийн төсөв;

18.1.2.бүсийн болон олон улсын байгууллагын хамтын ажиллагааны оролцооны санхүүжилт;

18.1.3.бусад эх үүсвэр.

18.2.Малын генетик нөөцийн үйл ажиллагааны дараахь зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

18.2.1.малын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, үндэсний генийн санг бүрдүүлэх, ажиллуулах;

18.2.2.малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх;

18.2.3.төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх болон үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах, гойд ашиг шимт сайжруулагч мал шалгаруулж улсын бүртгэл хөтлөх;

18.2.4.малд удам зүйн үнэлгээ хийх үйл ажиллагааны зардал;

18.2.5.биотехнологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

18.2.6.хязгаарлагдмал нөөц, тархац, ашиглалттай, үл давтагдах өвөрмөц үнэ цэн бүхий малыг хамгаалах;

18.2.7.мал, үржүүлгийн бүтээгдэхүүн, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын үзлэг, шинжилгээ хийх.

18.3.Малын генетик нөөцийн үйл ажиллагааны дараахь зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ:

18.3.1.батлагдсан үүлдэр, омгийн малын генетик нөөцийн биологийн ашигт шинж чанарыг бататган сайжруулах, үржлийн ажлын ололтыг хянан баталгаажуулах, цөм сүргийг сайжруулах;

18.3.2.малын бэлчээр сайжруулах, хадлан, тэжээл бэлтгэх, усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ;

18.3.3.тодорхой үүлдэр, омгийн малыг гардан маллаж, үүлдэрлэг байдлыг нь хамгаалж, сайжруулж буй малчин өрхөд үзүүлэх дэмжлэг, урамшуулал;

18.3.4.өсвөр хээлтүүлэгчийг шилэн сонгож, ялган суурилж, үржлийн нас хүртэл бойжуулах;

18.3.5.малын генетик нөөцийн сурталчилгааны зардал;

18.3.6.Энэ хуулийн 16.4.6-д заасан арга хэмжээний зардал.

18.4.Малын генетик нөөцийн үйл ажиллагааны дараахь зардлыг малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээд хариуцан санхүүжүүлнэ:

18.4.1.энэ хуулийн 6.2, 6.3, 8.4.4, 8.4.7, 11.6.6, 14.1.1, 14.1.3, 14.1.7-д заасан арга хэмжээний зардал;

18.4.2.тухайн орон нутагт үржүүлэх үүлдэр, омгийн малын малын үүлдрийн ба аж ахуйн ашигтай шинж чанарыг бататган сайжруулах, цөм сүрэг

бүрдүүлэх, шилж үржүүлэх;

18.4.3.хадлан, тэжээл бэлтгэх, худаг, уст цэг, малын байр, хашааны хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ.

19 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

19.2.Энэ хуулийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

20 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

20.1.Энэ хуулийг оны дүгээр сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

⁴ Төрийн албаны тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.